

**Ерөнхий мэдээлэл****2023 оны 12-р сарын 31-ээр тасалбар болсон жил****Компанийн нэр** Монос Хүнс ХК**Улсын бүртгэлийн дугаар** 9010002005**Үндсэн үйл ажиллагаа** Компанийн үндсэн үйл ажиллагаа нь жүүс, ундаа, чихэр, үрэл, цай, зөөлөн капсултай бүтээгдэхүүн үйлдвэрлэл болон гадаад худалдаа болно.**Хувьцаа эзэмшигчид**

	<b>Хувьцааны тоо</b>	<b>Эзэмшлийн хувь</b>
Л. Хүрэлбаатар	286,198,433	70.00%
Ц. Цэцэнзориг	14,284,706	3.49%
Ц. Ганзориг	14,120,665	3.45%
Х. Ананд	10,929,975	2.67%
А. Түмэнжаргал	5,996,176	1.47%
Л. Эрдэнэчимэг	4,630,628	1.13%
Б. Пунсалмаа	4,466,005	1.09%
Бусад	68,223,840	16.69%
	<b>408,850,428</b>	<b>100%</b>

**Гүйцэтгэх Удирдлага**Гүйцэтгэх захирал  
Санхүү хариуцсан захирал  
Үйл ажиллагаа хариуцсан захиралА. Отгондарь  
Ц. Дэлгэрмаа  
П. Тодрол**Төлөөлөн удирдах зөвлөл**ТУЗ-ийн дарга  
ТУЗ-ийн хараат бус гишүүн  
ТУЗ-ийн хараат бус гишүүн  
ТУЗ-ийн хараат бус гишүүн  
ТУЗ-ийн хараат гишүүн  
ТУЗ-ийн хараат гишүүн  
ТУЗ-ийн хараат гишүүн  
ТУЗ-ийн хараат гишүүн  
ТУЗ-ийн хараат гишүүн  
ТУЗ-ийн нарийн бичгийн даргаХ. Ананд  
Б. Гантулга  
О. Лхагвасүрэн  
Д. Энхтүвшин  
Л. Хүрэлбаатар  
Ч. Баттогтох  
А. Отгондарь  
Х. Солонго  
Ц. Цэцэгбадам  
Н. Цагаанхүү**Байнгын хаяг****Монос Хүнс ХК**  
205-2 тоот, Чингисийн өргөн чөлөө, Хан-Уул дүүрэг, 2-р хороо,  
Улаанбаатар хот, Монгол Улс**Аудитор****БДО Аудит ХХК**  
Юнион Бюлдинг Б блок, 15-р давхар, 1502 тоот,  
Парисийн гудамж, Нарны зам-62,  
Сүхбаатар дүүрэг, 1-р хороо,  
Улаанбаатар хот, Монгол Улс

**2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
санхүүгийн тайлан бэлтгэх болон батлах талаарх  
Удирдлагын Хариуцлагын Мэдэгдэл**

Энэхүү тайлангийн 3-7 дахь хуудсанд тусгагдсан хараат бус аудиторын тайланд дурдсан хараат бус аудиторын дүгнэлттэй хамт үншигдах дараах мэдэгдэл нь Монос Хүнс Хувьцаат Компанийн (цаашид 'Компани' гэх) 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайлантай холбоотой удирдлагын үүрэг хариуцлага болон аудиторын хариуцлагыг тусад нь илэрхийлэх үүднээс хийгдсэн болно.

Компанийн удирдлага нь эдгээр санхүүгийн тайлангуудыг Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ('СТОУС')-ын дагуу үнэн зөв бэлтгэх үүрэгтэй болно. Бид санхүүгийн тайлантай холбоотой үүрэг хариуцлагаа ухамсарлан, санхүүгийн тайлангаа Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ('СТОУС'), Монгол улсад хүчин төгөлдөр мөрдөгдөж буй нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон холбогдох заавар журмын дагуу үнэн зөв бэлтгэсэн гэдгээ баталж байна.

Компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн тайланг гаргахыг зөвшөөрч батлав.

 <b>Х. АНАНД</b> ТУЗ-ийн дарга	 <b>МОНОС ХҮНС</b> <b>ХК</b> 5369927 • 11192697	 <b>А. ОТГОНДАРЬ</b> Гүйцэтгэх захирал	 <b>Ц. ДЭЛГЭРМАА</b> Санхүү хариуцсан захирал
---	---	---	---

Огноо: 2024 оны 04 дүгээр сарын 10

Улаанбаатар хот, Монгол улс



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН

МОНОС ХҮНС ХК -ийн Хувьцаа эзэмшигчдэд

### Санхүүгийн тайлангийн аудитын талаарх тайлан

#### Санал дүгнэлт

Бид Монос Хүнс ХК ('Компани')-ийн дараах санхүүгийн тайлангуудад аудит хийлээ:

- 2023 оны 12 дугаар сарын 31-ээрх санхүүгийн байдлын тайлан;
- Энэ өдрөөр тасалбар болсон жилийн ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан, өмчийн өөрчлөлтийн тайлан, мөнгөн гүйлгээний тайлангууд; болон
- Нягтлан бодох бүртгэлийн материаллаг бодлогуудын мэдээллийг агуулсан санхүүгийн тайлангийн тэмдэглэлүүд.

Бидний дүгнэлтээр, хавсаргасан санхүүгийн тайлангууд нь компанийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрийн санхүүгийн байдал, энэ өдрөөр тасалбар болсон жилийн санхүүгийн гүйцэтгэл болон мөнгөн гүйлгээг бүх материаллаг талаараа Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандартын Зөвлөл (НББОУСЗ)-өөс гаргасан Санхүүгийн Тайлагналын Олон Улсын Стандарт ('СТОУС')-ын дагуу үнэн зөв илэрхийлсэн байна.

#### Санал дүгнэлтийн үндэслэл

Бид аудитаа Аудитын Олон Улсын Стандарт ('АОУС')-ын дагуу хийсэн. Эдгээр стандартын дагуу хүлээх үүрэг хариуцлагаа энэ тайлангийнхаа *Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага* гэсэн хэсэгт харуулсан. Бид Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Олон Улсын Стандартын Зөвлөл ('НБЭЗОУСЗ')-ийн Мэргэжлийн Нягтлан Бодогчдын Ёс Зүйн Дүрэм болон Монгол улсад мөрдүүлэхээр шаарддаг санхүүгийн тайлангийн аудиттай холбоотой ёс зүйн шаардлагуудын дагуу компаниас хараат бус байсан бөгөөд НБЭЗОУСЗ-ийн дүрэм болон эдгээр ёс зүйн шаардлагын дагуу бусад ёс зүйн үүрэг хариуцлагаа бүрэн биелүүлсэн болно. Бидний олж авсан аудитын нотолгоо нь бидний гаргасан санал дүгнэлтийн үндэслэл болоход хангалттай бөгөөд зохистой гэж бид найдаж байна.

#### Аудитын гол асуудал

Бидний мэргэжлийн шүүн тунгаалтаар, аудитын гол асуудлууд гэж тайлант жилийн санхүүгийн тайлангийн аудитад хамгийн их нөлөөтэй асуудлууд юм. Санхүүгийн тайланд гүйцэтгэсэн аудитынхаа хүрээнд эдгээр асуудлуудыг нэгтгэсэн байдлаар авч үзсэн ба дүгнэлт гаргахдаа эдгээр асуудлуудад тус бүрчлэн тусад нь дүгнэлт гаргаагүй болно.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

### Аудитын гол асуудал

### Аудитын хариу

#### 1 Засгийн газрын буцалтгүй тусламж

Компани “Хүнсний хангамж, аюулгүй байдлыг хангах талаар авах зарим арга хэмжээний тухай” УИХ-ын 2022 оны 36 дугаар тогтоолын хүрээнд тайлант жилд Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас хүнсний үйлдвэрлэлийг дэмжих зорилготой, хөрөнгө оруулалтын зориулалттай 18 тэрбум төгрөгийн зээл болон эргэлтийн хөрөнгийн зориулалттай 12 тэрбум төгрөгийн зээлийг хөнгөлөлттэй нөхцөлөөр хүлээн авсан. Уг зээлийн гэрээний хүрээнд хүлээн авсан зээлийн анхны болон дараа үеийн хэмжилтийн нарийн төвөгтэй байдал, мөн засгийн газрын буцалтгүй тусламж нь онцгой шинжтэй ажил гүйлгээ учир бид эдгээр асуудлыг аудитын гол асуудлаар тодорхойлсон.

2023 оны 12-р сарын 31-ний байдлаар хорогдуулсан өртгөөр хэмжигдсэн тус зээлийн дүн 23,550,500 мянган төгрөг (2022: 0) байна.

2023 оны 12-р сарын 31-ний байдлаар санхүүгийн тайланд хүлээн зөвшөөрсөн хойшлогдсон засгийн газрын буцалтгүй тусламжийн орлогын дүн дүн 6,449,500 мянган төгрөг (2022: 0) байна.

Хавсаргасан санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 12 болон 24-өөс үзнэ үү.

Засгийн газрын буцалтгүй тусламжийн орлого хүлээн зөвшөөрөлт болон зээлийн бодит үнэ цэнийн хэмжилт, хүлээн зөвшөөрөлттэй холбоотойгоор :

- Засгийн газраас тавьж буй шалгуур үзүүлэлт, тэдгээрийг хангасан байдалд үндэслэн Засгийн газрын буцалтгүй тусламжийн шалгуур хангаж буй эсэхийг шалгасан;
- Зээлийн анхны бодит үнэ цэний тооцооллыг давтан гүйцэтгэсэн;
- Хойшлогдсон засгийн газрын буцалтгүй тусламжийн орлогын хорогдуулалт нь ашиг алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайланд үнэн зөв бүртгэсэн эсэхийг шалгасан.

### Аудитын гол асуудал

### Аудитын хариу

#### 2 Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээ

Компани нь тайлант жилийн эцсээр Санхүүгийн байдлын тайлангийн Өмч, барилга, тоног төхөөрөмжид багтсан барилга, тоног төхөөрөмжийн ангилал дахь 10,670,162 мянган төгрөгийн дансны үнэ бүхий хөрөнгийг хөндлөнгийн, хараат бус, мэргэжлийн үнэлгээчнээр дахин үнэлүүлж, 2,216,467 мянган төгрөгийн (татварын дараах) дахин үнэлгээний нэмэгдэл хүлээн зөвшөөрч бүртгэсэн. Бодит үнэ цэний тооцоололд ашиглагдаж буй үл ажиглагдах орц мэдээллээс үүдэлтэй тооцооллын тодорхойгүй байдал, үнэлгээний арга зүй, тооцооллын нарийн төвөгтэй байдал зэргээс шалтгаалж бид аудитын гол асуудал болгон авч үзсэн.

Хавсаргасан санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 20-оос үзнэ үү.

Бид барилга, тоног төхөөрөмжийн дахин үнэлгээний хэмжилттэй холбоотой үл үндэслэлтэй нотолгоо олж авах зорилгоор үнэлэгдэж буй хөрөнгүүдийн үнэлгээний арга зүй, арилжаалагдаж буй хөрөнгийн зах зээл, үл ажиглагдах орц мэдээллүүдийн талаар мэдлэг, туршлага бүхий эксперт томилон ажиллуулсан.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

Аудитын гол асуудал

Аудитын хариу

3

**Дуусаагүй барилгын өртөг бүрдэлт ба хүлээн зөвшөөрөлт:**

Компани нь эрүүл мэндийг дэмжсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлийн хүчин чадлаа гурав дахин нэмэгдүүлэх зорилготой MFC 2.0 төслийн шинэ үйлдвэрийн барилгын ажлыг 2022 онд эхлүүлж 2023 онд барилгын ажил идэвхитэй үргэлжлүүлж, тайлант жилийн эцсээр нийт 22,936,773 мянган төгрөгийн өртгийг дуусаагүй барилга, тоног төхөөрөмж дансанд хуримтлуулан бүртгэсэн байна. Бид дуусаагүй барилгын өртөг бүрдэлт, капиталжих хүүний өртгийн тооцооллын нарийн төвөгтэй байдлын улмаас аудитын гол асуудал болгон авч үзсэн.

Бид төслийн хүрээнд хуримтлуулан бүртгэж буй өртгүүдийг зардлын нэр төрөл тус бүрээр шинжилж, төслийн өртөгт капиталжих шалгуур хангасан байдал болон дуусаагүй барилгын өртөгт капиталжуулсан зээлийн өртгийн тооцооллын үл үндэслэлтэй байдлыг давтан тооцоолж шалгасан.

Хавсаргасан санхүүгийн тайлангийн Тэмдэглэл 20-оос үзнэ үү.

### Бусад мэдээлэл

Удирдлага нь бусад мэдээлэлд үүрэг хариуцлага хүлээдэг. Бусад мэдээлэл нь жилийн тайланд орсон мэдээллээс бүрдэх бөгөөд түүнд санхүүгийн тайлан ордог ч бидний аудиторын тайлан ордоггүй.

Санхүүгийн тайланд гаргасан бидний дүгнэлт нь бусад мэдээллийг хамардаггүй бөгөөд бид бусад мэдээллийн талаар аливаа баталгаажилтын дүгнэлт гаргахгүй.

Санхүүгийн тайлангийн аудиттайгаа холбогдуулан бидний хүлээх үүрэг хариуцлага бол бусад мэдээллийг уншиж, ингэснээр бусад мэдээлэл нь санхүүгийн тайлан эсвэл аудитаар олж авсан бидний мэдлэг эсвэл өөр хэлбэрээр материаллагаар буруу илэрхийлэгдсэн байж болох эсэх тухай материаллаг үл нийцлийг авч үзэхэд оршдог. Бид өөрсдийн гүйцэтгэсэн ажил дээрээ суурилан энэхүү бусад мэдээлэл нь материаллаг буруу илэрхийлэлтэй байна гэж дүгнэвэл тухайн бодит байдлыг тайлагнахыг биднээс шаарддаг. Уг тайланг унших үедээ түүнд материаллаг буруу илэрхийлэл байгаа гэж үзвэл бид энэ асуудлаар засаглах эрх бүхий этгээдүүдэд мэдээлэх ёстой. Бидэнд ингэж тайлагнах зүйл байхгүй болно.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

### Санхүүгийн тайланд Удирдлага ба Засаглах удирдлагын хүлээх үүрэг хариуцлага

Санхүүгийн тайлангуудыг СТОУС -ын дагуу бэлтгэж, үнэн зөв толилуулах, болон алдаа юм уу заль мэхнээс үүдэлтэй материаллаг буруу илэрхийллээс ангид санхүүгийн тайлан бэлтгэх боломж бүрдүүлэхэд зайлшгүй шаардлагатай тийм дотоод хяналтыг тодорхойлох нь удирдлагын үүрэг хариуцлага юм.

Санхүүгийн тайланг бэлтгэж байхдаа удирдлага нь компанийг татан буулгах юм уу үйл ажиллагааг нь зогсоох эсвэл ингэхээс өөр бодит сонголт байхгүй байхаас бусад тохиолдолд удирдлага өөдрөг төсөөллөөр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх компанийн чадамжийг үнэлж, шаардлагатай бол өөдрөг төсөөлөлтэй холбоотой асуудлуудын талаар тодруулга хийх, нягтлан болох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг ашиглах үүрэг хариуцлага хүлээнэ.

Засаглах удирдлага нь компанийн санхүүгийн тайлагналын үйл явцад хяналт тавих үүрэг хариуцлагатай байна.

### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага

Заль мэх эсвэл алдаанаас үүдсэн материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлангууд нь бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажилтыг олж авч, өөрийн санал дүгнэлтийг багтаасан аудиторын тайлан гаргах нь бидний зорилго юм. Ул үндэслэлтэй баталгаажилт нь баталгаажилтын өндөр түвшин боловч АОУС-ын дагуу хийгдсэн аудитаар оршин байгаа материаллаг алдаа зөрчлийг цаг ямагт илрүүлж байна гэж амласан баталгаа гаргадаггүй. Алдаа зөрчил нь заль мэхнээс эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд хэрэв тэр нь дангаараа эсвэл нийлэхээрээ санхүүгийн тайланд үндэслэн түүнийг хэрэглэгчдийн гаргах эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх магадлалтай бол материаллагт тооцогддог.

АОУС-ын дагуу хийсэн аудитын нэг хэсэг байдлаар бид мэргэжлийн шийдэл гарган, аудитын туршид мэргэжлийн үл итгэх үзлийг баримтлан ажилладаг. Бид мөн:

- Заль мэх эсвэл алдааны улмаас санхүүгийн тайлан материаллаг алдаатай илэрхийлэгдэх эрсдэлийг тодорхойлж, түүнийг үнэлэн уг эрсдэлд тохирох аудитын горимыг боловсруулан хэрэгжүүлж, өөрсдийн санал дүгнэлтийн үндэслэл болохуйц хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоог олж авдаг. Заль мэхнээс үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэл нь алдаанаас үүссэн материаллаг алдааг илрүүлэхгүй байх эрсдэлээс харьцангуй их байдаг. Учир нь заль мэхэнд хуйвалдаан, баримт бичгийг хуурамчаар үйлдэх, санаатайгаар орхигдуулах, буруу тайлагнах, дотоод хяналтыг үл ойшоох явдлууд орсон байж болно.
- Компанийн дотоод хяналтын үр ашигт байдлын талаар санал дүгнэлт гаргах зорилгоор биш харин тухайн нөхцөл байдалд тохирох аудитын горимыг боловсруулах зорилгоор аудитад хамаарах дотоод хяналтын талаар ойлголт олж авдаг.
- Удирдлагын ашигласан нягтлан бодох бүртгэлийн бодлогын тохиромжтой байдал, хийсэн нягтлан бодох бүртгэлийн тооцоолол болон холбогдох тодруулгын үл үндэслэлтэй байдлыг үнэлдэг.



## ХАРААТ БУС АУДИТОРЫН ТАЙЛАН (үргэлжлэл)

### Санхүүгийн тайлангийн аудитад Аудиторын хүлээх үүрэг хариуцлага (үргэлжлэл)

- Мөн олж авсан аудитын нотолгоонд үндэслэн компанийн тасралтгүйгээр үйл ажиллагаагаа үргэлжлүүлэх чадамжид мэдэгдэхүйц эргэлзээ төрүүлэхүйц үйл явдал, нөхцөл байдалтай холбоотой материаллаг тодорхой бус байдал байгаа эсэхийг тодорхойлж, нягтлан бодох бүртгэлийн өөдрөг төсөөллийн суурийг удирдлага зохистойгоор хэрэглэсэн эсэхийг дүгнэдэг. Хэрэв бид материаллаг хэмжээний тодорхой бус байдал оршин байна гэж үзвэл аудиторын тайландаа түүнтэй холбоотой санхүүгийн тайлангийн тодруулгад анхаарал хандуулах эсвэл хийсэн тодруулга нь хангалтгүй байна гэж үзвэл аудитын санал дүгнэлтээ өөрчилдөг. Бидний дүгнэлт нь аудиторын тайлан гаргах өдөр хүртэлх олж авсан аудитын нотолгоонд суурилдаг. Гэхдээ ирээдүйн үйл явдал эсвэл нөхцөлүүд нь компанийг өөдрөг төсөөллөө үргэлжлүүлэхээ зогсооход хүргэх нөлөө үзүүлж болно.
- Тодруулгыг багтаагаад санхүүгийн тайлангийн ерөнхий толилуулга, бүтэц, агуулга ба санхүүгийн тайлангууд нь үнэн зөв толилуулгын шаардлагыг хангахүйц хэмжээнд гол гол ажил гүйлгээ ба үйл явдлыг илэрхийлсэн эсэхийг үнэлдэг.

Бид аудитын төлөвлөсөн цар хүрээ ба хугацаа, аудитынхаа явцад олж илрүүлсэн дотоод хяналт дахь томоохон зөрчил дутагдлыг оруулаад нөлөө бүхий аудитын илрүүлэлтүүд, бусад асуудлуудаар засаглах эрх бүхий удирдлагатай харилцдаг.

Бид хараат бус байдлын тухай холбогдох ёс зүйн шаардлагуудад нийцсэн мэдэгдлээр засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдийг хангадаг ба мөн бид эдгээр хүмүүстэй бүх харилцаа холбоо болон шаардлагатай гэж үзвэл аюул заналыг арилгахтай холбоотой авч хэрэгжүүлсэн үйл ажиллагаа болон хэрэглэсэн хамгаалалт гэх зэрэг бидний хараат бус байдлын хүрээнд бодолцож үзвэл зохих асуудлаар харилцдаг.

Засаглах эрх мэдэл бүхий этгээдүүдтэй харилцсан асуудлуудаас тайлант үеийн санхүүгийн тайлангийн аудитад гол асуудлууд гэж үздэг. Хууль, дүрэм журмаар аливаа асуудлыг олон нийтэд мэдээлэхийг хориглосон эсвэл тун ховор тохиолдолд аудиторын тайланд тухайн асуудлыг мэдээлэх нь тухайн мэдээллээс олон нийтийн хүртэх үр өгөөжөөс илүү сөрөг үр дагавартай гэж үзсэнээс бусад тохиолдолд тэдгээр асуудлыг аудиторын тайландаа тодорхойлдог.



Л. БАЯРЦОГЗОЛ  
БДО Аудит ХХК  
УЛААНБААТАР ХОТ  
СҮХБААТАР ДҮҮРЭГ, 1-р КОРОО,  
Парисийн гудамж, Нарны зам-62  
Юнион Бюлдинг Б блок, 1502 тоот өрөө

Огноо: 2024.04.10



МОНОС ХҮНС ХК

2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
Ашиг, алдагдал болон бусад дэлгэрэнгүй орлогын тайлан

	Тэм	2023 он мян.төг	2022 он мян.төг
Худалдан авагчидтай байгуулсан гэрээний орлого	5	31,676,949	28,216,578
Борлуулалтын өртөг	6	(17,203,847)	(15,928,711)
<b>Нийт ашиг</b>		<b>14,473,102</b>	<b>12,287,867</b>
Бусад орлого	7	35,531	74,409
Ерөнхий ба удирдлагын зардал	8	(3,046,507)	(2,691,491)
Борлуулалт ба маркетингийн зардал	9	(6,711,229)	(5,100,559)
Бусад зардал	11	(147,950)	(138,191)
<b>Үндсэн үйл ажиллагааны ашиг</b>		<b>4,602,947</b>	<b>4,432,035</b>
Санхүүгийн орлого	12	61,188	20,126
Санхүүгийн зардал	12	(725,111)	(826,208)
Бусад олз, гарз	13	(21,645)	2,966
<b>Татварын өмнөх ашиг</b>		<b>3,917,379</b>	<b>3,628,919</b>
Орлогын албан татварын зардал	14	(437,089)	(441,581)
<b>Тайлант жилийн ашиг</b>		<b>3,480,290</b>	<b>3,187,338</b>
<b>Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого:</b>			
<b>Ашиг, алдагдалд дахин ангилагдахгүй зүйлс</b>			
Дахин үнэлгээний олз/(гарз)	20	2,216,467	-
Ашиг, алдагдалд дахин ангилагдахгүй зүйлсийн татвар	14	221,647	-
<b>Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого</b>		<b>2,438,114</b>	<b>-</b>
<b>Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг</b>		<b>5,918,404</b>	<b>3,187,338</b>
<b>Нэгж хувьцаанд ногдох ашиг</b>			
Суурь ашиг – төгрөг	15	8.51	7.80
Хорогдуулсан ашиг – төгрөг	15	8.51	7.80

2023 оны 12-р сарын 31-ний өдөр хуудас 8-74-д тусгагдсан санхүүгийн тайлангуудыг баталж, Төлөөлөн Удирдах Зөвлөлийн нэрийн өмнөөс гарын үсэг зурахыг зөвшөөрөв.

  
 Х.Ананд  
 ТУЗ-ийн дарга



МОНОС ХҮНС ХК

2023 оны 12-р сарын 31-ний өдрөөрх  
Санхүүгийн байдлын тайлан

	Тэм	2023 оны 12 сарын 31 мян.төг	2022 оны 12 сарын 31 мян.төг
<b>Хөрөнгө</b>			
<b>Эргэлтийн хөрөнгө</b>			
Бараа материал	16	4,944,922	7,749,998
Худалдааны болон бусад авлага	17	4,112,780	3,768,300
Урьдчилж төлсөн төлбөр	18	2,568,010	658,700
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгө	19	27,537,479	295,524
<b>Нийт эргэлтийн хөрөнгө</b>		<b>39,163,191</b>	<b>12,472,522</b>
<b>Эргэлтийн бус хөрөнгө</b>			
Өмч, барилга, тоног төхөөрөмж	20	36,432,400	22,188,419
Хөрөнгө ашиглах эрх	21	967,489	-
Биет бус хөрөнгө	22	414,045	525,805
Бусад авлага	17	22,266	14,000
Урьдчилж төлсөн төлбөр	18	260,945	1,236,588
Хойшлогдсон татварын хөрөнгө	14	76,130	70,222
<b>Нийт эргэлтийн бус хөрөнгө</b>		<b>38,173,275</b>	<b>24,035,034</b>
<b>Нийт хөрөнгө</b>		<b>77,336,466</b>	<b>36,507,556</b>
<b>Өр төлбөр</b>			
<b>Богино хугацаат өр төлбөр</b>			
Худалдааны болон бусад өглөг	23	3,448,740	3,162,214
Гэрээний өр төлбөр	5	48,499	58,745
Зээл болон өр төлбөр	24	15,434,400	10,690,823
Түрээсийн өр төлбөр	21	112,311	-
Орлогын татварын өглөг	14	185,641	449,083
Нөөц	16	254,886	184,828
<b>Нийт богино хугацаат өр төлбөр</b>		<b>19,484,477</b>	<b>14,545,693</b>

Хүснэгтийн үргэлжлэлийг дараагийн хуудаснаас харна уу



МОНОС ХҮНС ХК

2023 оны 12-р сарын 31-ний өдрөөрх  
Санхүүгийн байдлын тайлан

	Тэм	2023 оны 12 сарын 31 мян.төг	2022 оны 12 сарын 31 мян.төг
<b>Урт хугацаат өр төлбөр</b>			
Зээл болон өр төлбөр	24	29,025,580	4,671,201
ЗГ-ын буцалтгүй тусламжийн хойшлогдсон орлого	14; 24	6,449,500	-
Түрээсийн өр төлбөр	21	157,211	-
Хойшлогдсон татварын өглөг	14	213,518	-
<b>Нийт урт хугацаат өр төлбөр</b>		<b>35,845,809</b>	<b>4,671,201</b>
<b>Нийт өр төлбөр</b>		<b>55,330,286</b>	<b>19,216,894</b>
<b>Өмч</b>			
Хувьцаат капитал	26	2,318,182	2,318,182
Нэмж төлөгдсөн капитал	26	6,835,733	6,835,733
Дахин үнэлгээний нэмэгдэл	20	2,508,104	410,914
Хуримтлагдсан ашиг		10,344,161	7,725,833
<b>Нийт өмч</b>		<b>22,006,180</b>	<b>17,290,662</b>
<b>Нийт өмч ба өр төлбөр</b>		<b>77,336,466</b>	<b>36,507,556</b>

Х.Ананд  
ТУЗ-ийн дарга





МОНОС ХҮНС ХК

2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
Өмчийн өөрчлөлтийн тайлан

	Хувьцаат капитал	Нэмж төлөгдсөн капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан ашиг	Нийт өмч
	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг	мян.төг
<b>2023 оны 01 сарын 01-ний үлдэгдэл</b>	2,318,182	6,835,733	410,914	7,725,833	17,290,662
Тайлант жилийн ашиг	-	-	-	3,480,290	3,480,290
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	-	-	2,216,467	-	2,216,467
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг	-	-	2,216,467	3,480,290	5,696,757
Хөрөнгийн дахин үнэлгээний хэрэгжилт	-	-	(119,277)	119,277	-
Төлсөн ногдол ашиг	-	-	-	(981,240)	(981,240)
<b>2023 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,318,182</b>	<b>6,835,733</b>	<b>2,508,104</b>	<b>10,344,161</b>	<b>22,006,180</b>
<b>2022 оны 01 сарын 01-ний үлдэгдэл</b>	<b>2,318,182</b>	<b>6,835,733</b>	<b>451,941</b>	<b>5,315,170</b>	<b>14,921,026</b>
Тайлант жилийн ашиг	-	-	-	3,187,338	3,187,338
Тайлант жилийн бусад дэлгэрэнгүй орлого	-	-	-	-	-
Тайлант жилийн нийт дэлгэрэнгүй ашиг	-	-	-	3,187,338	3,187,338
Хөрөнгийн дахин үнэлгээний хэрэгжилт	-	-	(41,027)	41,027	-
Төлсөн ногдол ашиг	-	-	-	(817,702)	(817,702)
<b>2022 оны 12 сарын 31-ний үлдэгдэл</b>	<b>2,318,182</b>	<b>6,835,733</b>	<b>410,914</b>	<b>7,725,833</b>	<b>17,290,662</b>



14-74 дүгээр хуудсан дахь тэмдэглэлүүд нь эдгээр санхүүгийн тайлангуудын салшгүй хэсэг болно.



МОНОС ХҮНС ХК

2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
Мөнгөн гүйлгээний тайлан

	Тэм	2023 он мян.төг	2022 он мян.төг
<b>Үндсэн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
<b>Тайлант жилийн ашиг</b>		<b>3,480,290</b>	<b>3,187,337</b>
<i>Тохируулга:</i>			
Орлогын албан татварын зардал	15	437,089	441,581
Өмч, барилга, тоног төхөөрөмжийн элэгдэл	20	1,239,415	1,113,498
Биет бус хөрөнгийн хорогдуулга	22	111,760	108,462
Хөрөнгө ашиглах эрхийн хорогдуулга	21	121,943	57,634
Гадаад валютын ханшийн зөрүүгийн хэрэгжээгүй гарз/(олз)	12	18,602	(23,657)
Бараа материал данснаас хассаны гарз	11	143,786	137,649
Үнийн бууралтын гарз	13	18,361	15,159
Өмч, барилга, тоног төхөөрөмж борлуулсны олз	13	-	(11,364)
Өмч, барилга, тоног төхөөрөмж данснаас хассаны гарз	13	3,285	1,430
Ашиглах эрхтэй хөрөнгө данснаас хассаны олз	13	-	(8,191)
Хүүгийн орлого	12	(11,025)	-
Зээлийн хүүгийн зардал	12	598,125	634,425
Түрээсийн хүүгийн зардал	21	32,364	13,936
<b>Ажлын капиталын өөрчлөлтийн өмнөх үндсэн үйл ажиллагааны ашиг</b>		<b>6,193,995</b>	<b>5,667,899</b>
Бараа материалын (өсөлт)/бууралт		2,712,986	(2,095,658)
Худалдааны болон бусад авлагын (өсөлт)/бууралт		(352,746)	(821,977)
Худалдааны болон бусад өглөгийн өсөлт/(бууралт)		(48,192)	1,748,416
Гэрээний өр төлбөрийн өсөлт/(бууралт)		(10,246)	30,947
Урьдчилж төлсөн төлбөрийн (өсөлт)/бууралт		(1,909,310)	(948,549)
<b>Үндсэн үйл ажиллагаанаас бий болсон мөнгө</b>		<b>6,586,487</b>	<b>3,581,078</b>
Төлсөн орлогын албан татвар	14	(714,566)	(235,227)
<b>Үндсэн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>5,871,921</b>	<b>3,345,851</b>

Хүснэгтийн үргэлжлэлийг дараагийн хуудаснаас харна уу



МОНОС ХҮНС ХК

2023 оны 12-р сарын 31-ний өдрөөр тасалбар болсон жилийн  
Мөнгөн гүйлгээний тайлан (үргэлжлэл)

	Тэм	2023 он мян.төг	2022 он мян.төг
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Худалдан авсан өмч, барилга, тоног төхөөрөмж	24, 29	(9,341,897)	(10,715,992)
Борлуулсан өмч, барилга, тоног төхөөрөмж	20	-	11,364
Худалдан авсан биет бус хөрөнгө	22	-	(33,058)
Ашиглах эрхтэй хөрөнгө олж эзэмшихэд төлсөн мөнгө	21	(734,242)	-
Хүлээн авсан хүү	16	11,025	-
<b>Хөрөнгө оруулалтын үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>(10,065,114)</b>	<b>(10,737,686)</b>
<b>Санхүүгийн үйл ажиллагааны мөнгөн гүйлгээ</b>			
Авсан зээл болон өр төлбөр	24, 29	50,703,799	17,015,413
Зээл болон өр төлбөрийн эргэн төлөлт	24, 29	(15,299,888)	(7,729,507)
Төлсөн ногдол ашиг	26	(981,240)	(817,701)
Түрээсийн өр төлбөрийн үндсэн төлбөрийн төлөлт	21	(118,032)	(53,136)
Түрээсийн өр төлбөрийн хүүгийн төлбөрийн төлөлт	21	-	(13,936)
Зээл болон өр төлбөрийн хүүгийн төлбөрийн төлөлт	24, 29	(2,859,416)	(995,426)
<b>Санхүүгийн үйл ажиллагааны цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>31,445,223</b>	<b>7,405,707</b>
<b>Тайлант жилд бий болсон нийт цэвэр мөнгөн гүйлгээ</b>		<b>27,252,030</b>	<b>13,872</b>
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл</b>	<b>19</b>	<b>295,524</b>	<b>257,995</b>
Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн гадаад валютын ханшийн өөрчлөлтийн нөлөө		(10,075)	23,657
<b>Мөнгө ба түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл</b>	<b>19</b>	<b>27,537,479</b>	<b>295,524</b>

Мөнгөн гүйлгээний тайланг дэмжих мэдээллийг Тэмдэглэл 29-өөс үзнэ үү

Х.Ананд  
ТУЗ-ийн дарга

